



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 9/61

Мандалговь

Г Бичил уурхай эрхлэгчдээс Т

жонш худалдан авах аж ахуйн нэгж
сонгох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3, "Ажлын хэсэг томилох тухай" аймгийн Засаг даргын 2018.09.05-ны А/369 дугаар захирамжийн 2 дахь заалт, уг захирамжаар томилогдсон ажлын хэсгийн 2019 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуралдааны тэмдэглэлийг дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Хулд сумын бичил уурхай эрхлэгчдээс жонш худалдан авах аж ахуйн нэгжээр "Тавин-Эх" ХХК-ийг сонгон шалгаруулж ажиллуулсугай.

Хоёр. Сумын Засаг дарга, худалдан авалт хийхээр сонгогдсон аж ахуйн нэгж, бичил уурхай эрхлэгчдийн хооронд гурвалсан гэрээ байгуулж ажиллахыг Хулд сумын Засаг дарга (Ч.Зоригтбаатар), бичил уурхай эрхлэг нөхөрлөлийн ахлагч, "Тавин-Эх" ХХК-ний захирал (Э.Анхбаяр)-д тус тус үүрэг болгосугай.

Гурав. Бичил уурхайн болон худалдан авалтын үйл ажиллагаа хууль тогтоомжийн дагуу явагдаж байгаад байнгын хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн Хяналтын Газар (Ш.Төрбат), Хулд сумын Засаг дарга (Ч.Зоригтбаатар), холбогдох хууль, хяналт, мэргэжлийн байгууллагуудын дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ



4880101R7